

12. *Иванова.Г.Ф.* Минералогия и геохимия вольфрамового оруденения Монголии. Изд-во Наука, Москва. 1976.

13. *Коваленко.В.И., Кузьмин.М.И., Антипин.В.С., Петров.Л.Л.* Топаз, содержащий кварцевый кератофир (онгонит)-новая разновидность субвулканических жильных пород магматического комплекса. Докл. АН СССР, том 199, №2, 1971.

БАЯНХОНГОРЫН БҮСИЙН УЛААН БУЛАГИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ДАХЬ ЦАГААН АЛТНЫ ЭРДЭСЖИЛТ

С.ДАНДАР¹, У.КЭМПЕ², Д.ВОЛЬФ², Г.БААСТ³

¹ШУТИС, Геологийн сургууль

²Герман улс Фрайберггийн Уул уурхайн Академи

³Баянхонгор Геологи Компани

Энэ мэдээлэлд Баянхонгорын бүсийн Улаанбулагийн алтны шороон ордоос анх удаа тогтоогдсон изоферроплатин болон өндөр сорьцтой алттай хамт ургалт үүсгэсэн осмиридиний талстуудын тухай оруулав.

Геологийн тогтоц

Улаан булагийн алтны шороон орд нь Жаргалантын нуруунаас эх авч урагшаа урссан Улаан булагийн голын хөндийд оршино. Энэ орчимд венд-доод кембрийн настай Жирэм нуруу группын Өлзийт голын формацийн гантигжсан шохойн чулуу, доломитийн үетэй хлорит-серициттэй, хлорит-амфиболтой, эпидот-хлорит-амфиболтой нөгөөн занар бүхий хурдас, дээд ордовикийн настай Цагаан дэл формацийн ногоон занар, хлорит-амфиболтой занар, цоохор өнгөтэй метаэлсжин, тэдгээрийг зүссэн доод кембрийн Баянхонгорын офиолит болон ордовикийн Цахир уулын бүрдлийн гранитоид чулуулаг тархсан байна. Мөн доод цэрдийн Девент формацийн нүүрслэг элсэн чулуу, алевролит бүхий алаг өнгөтэй молассоид хурдас тохиолдоно.

Баянхонгорын офиолит бүсийн серпентинитийн меланжийн томоохон блокууд дотор дунит-клинопироксенит-габброгийн кумулят сери, "дээд" габброид бүрдэл *Sheeted Dyke Complex* төрлийн дайкийн сери, глиокласт хэмхдэстэй базальтийн пиллоу-лавийн зузаалаг зэрэг офиолитийн үндсэн нэгжүүд тогтоогджээ (Төмөртоогоо.С, 2001 он). Энэ эвшлийн габброгийн Sm-Nd нас нь 569 ± 21 сая жил, метаморфизмийн K-Ar нас 484.5 ± 5.9 сая жил байна (Kerpezhinskas P.K., Kerpezhinskas K.B., and Dunkhtel.J.S., 1991). Энэ бүсийн доод палеозойн

боржинлог интрузивийн К-Аг изотопын насыг Германы геологич Д.Андреас 1968 онд 519 ба 551 сая жил, ОХУ-ын геологич Л.В.Заботкин 1988 онд 408±20 сая жил ба 451±2 сая жил, Япон улсын геологич Ю.Такахаши нар 1997 онд 469±9 сая жил буюу дээд кембри-ордовикийн настай болохыг тогтоосон байдаг. Улаанбулагийн алтны шороон орд нь дээд дөрөвдөгч-орчин үеийн насны саарал өнгөтэй 3.8-5.2 м зузаан саарал өнгөтэй аллювийн хурдсанд байрлана. Алт нь алтан шаргал өнгөтэй, 760-820 сорьцтой, 0.1-3 мм хэмжээтэй мөлгөржсөн мөхлөг үүсгэнэ. Мөн хромит, шльменит, магнетит, пирит, шеелит, ховроор киноварь тохиолдоно. Эдгээрээс шеелит нь октаэдр хэлбэртэй 0.1-2 мм талст байдлаар тохиолдоно.

Цагаан алтны эрдсүүд

Баянхонгорын офиолит бүхий бүсний Улаан-булагийн алтны шороон ордоос 0.5-1мм хэмжээтэй изоферроплатин ба осмиридикий талстуудыг минералогич Г.Бааст 2000 онд илрүүлсэн бөгөөд уг талстуудыг доктор У.Кэмпе, С.Дандар нар 2001 онд Герман улсын Фрайбергийн Уул Уурхайн Академийн Минералогийн хүрээлэнгийн растер электрон микроскопын судалгаа хийж тогтоосны үр дүнг доор оруулав.

Улаан булагийн алтны шороон ордоос олдсон
Изоферроплатины найрлага (%)

№	Сорьц	Pt	Fe	Rh	1-р хүснэгт.
					Бүгд
1.	ВН-3-1	90.49	8.70	0.81	100
2.	ВН-3-2	90.51	8.80	0.70	100.01
3.	ВН-5-1	91.45	8.21	0.34	100
4.	ВН-5-2	90.72	8.80	0.48	100
5.	ВН-8-1	91.21	8.79	-	100
6.	ВН-8-2	90.84	8.38	0.78	100
Дундаж		90.87	8.61	0.62	100.01

Улаан булагийн алтны шороон ордоос олдсон осмиридийн ба
түүнтэй ургалт үүсгэсэн алтны мөхлөгийн найрлага, %

№	Сорьц	Os	Ir	Ru	Fe	Au	2-р хүснэгт.
							Ag
1.	ВН-4-1	92.58	7.42	-	-	95.94	4.06
2.	ВН-4-2	89.32	10.68	-	-	-	-
3.	ВН-6-1	82.32	13.68	3.25	0.75	-	-
4.	ВН-6-2	82.00	15.40	1.97	0.64	-	-
5.	ВН-10-1	81.47	15.80	2.65	0.08	-	-
6.	ВН-10-2	84.62	11.29	2.81	1.28	-	-
7.	ВН-11-1	92.94	4.96	2.07	0.04	-	-
8.	ВН-11-2	90.56	7.30	2.05	0.09	95.04	4.96

Осмиридикий 0.5 мм хэмжээтэй 2 мөхлөгтэй ургалт үүсгэсэн алтны өндөр сорьцтой (Au=95.04-95.94%) талст тогтоогдов. Тэдгээр талстуудад мөнгө (Ag=4.06-4.96%) бага зэрэг агуулагдсан байна.

Дүгнэлт

Баянхонгорын бүсийн Улаанбулагийн алтны шороон ордыг ашиглах явцад анх удаа тогтоогдсон ЦАБМ-ийн найрлагад изоферроплатин, өндөр сорьцтой алтны мөхлөгтэй ургалт үүсгэсэн осмиридикий талстууд уг бүсийн доод кембрийн офиолит эвшилтэй орон зай, гарал үүслийн холбоотой байж болох юм.

Цаашид энэ бүсийн офиолит эвшлийг ЦАБМ-ийн эрдэсжилтийн талаас нь судлах нь зүйтэй юм.

Зохиол

1. *Kepzhinskas P.K., Kepzhinskas K.B., and Dunkhtel.J.S., Sm-Nd Age of the Oceanic Ophiolites of the Bayankhongor zone, Mongolia. Dokl.Akad.Nauk SSSR, 1991, vol. 316, no 3. pp 718-721.*

2. *Төмөртоогоо.С "Монгол орны офиолит эвшлүүд ба газрын царцдасын үүсэл", Геологийн асуудлууд., №3-4., УБ., МУИС., 2001., х 48-63.*

ТАВТСКОЕ ЗОЛОТОРУДНОЕ МЕСТОРОЖДЕНИЕ- ПЕРВЕНЕЦ МОНГОЛЬСКОЙ ЗОЛОТОРУДНОЙ ПРОМЫШЛЕННОСТИ

Д.БААТАР, Н.Г.БУЛДАКОВ.

Совместная Монголо-Российская акционерная
компания "Эм энд Даймонд"

Введение

В осуществлении программы "Золото", утвержденной Монгольским правительством в 1992 году, активно участвуют акционерные и частные компании Монголии и зарубежных стран, в том числе Монголо-Российские совместные предприятия и компании.

Совместная Монголо-Российская компания "Эм Энд Даймонд", созданная 22 ноября 1994 г. проводит разведочные и опытно-эксплуатационные работы в пределах Тавтского рудного поля, включающего одноименное месторождение.

В период с 1996 по 1999 г. компания проводила поисково-оценочные и разведочные работы, в результате которых подготовлены и утверждены запасы